

хамтран ажиллах урьдчилсан хэлэлцээрүүдийг байгуулж, мөн тус багийн гишүүн Профессор К.Заплетал Брно хотын их сургууль дээр Монголын геологийн талаар лекц уншиж байжээ.

1962 онд БНМАУ социалист орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны гол хэлбэр болох Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлд (РЭВ) элсэн орсноор хоёр орны геологийн салбар дахь хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж эхэлсэн байна. 1962 оны өвөл Геологийн төв байгууллагын орлогч дарга П.Кветонь, Төрийн төлөвлөгөөний комиссын ажилтан В.Мареш, Профессор Заплеталын лекцнээс анх Монголын тухай олж мэдэж байсан геологич П.Орел зэргийн гурван хүний бүрэлдэхүүнтэй баг Монголыг зорин гарсан байна.

Тэд Монгол геологичидтой уулзан зөвлөлдөж архивын материалын судалгаа хийсний эцэст найдвар төрүүлсэн хэд хэдэн орд газруудад анхаарлаа хандуулж хайгуул хийхийг зөвлөжээ. Энэхүү багийн айлчлалын үр дүнд Бүгд Найрамдах Социалист Чехословак Улсын төр Монголын зүгээс гаргасан геологийн хайгуул хийхэд тусламж үзүүлэх болон залуу геологчдийг бэлдэх хүсэлтүүдийг дэмжих шийдвэр гаргасан байна.

М. Краутерын удирдсан 5 хүний бүрэлдэхүүнтэй дараагийн баг геологийн ажлын дүнд хугацааны төслийн төлөвлөгөөг Монгол геологичидтой хамтран хэлэлцэн батлах зорилгоор 1962 оны 9-р сард Монгол Улсыг зорив.

Говийн нутагт геологийн ажил

хийх Монголын талын саналыг очиход зам хүндрэлтэй, усны болон ажиллах хүчний дутагдал зэрэг шалтгаануудын улмаас хүлээн аваагүй бөгөөд Чехословак-Монголын хамтарсан

болсон байв.

Тухайн газар нутагт 1960 онд Зөвлөлтийн геологичид урьдчилсан тандалт хийж байсан боловч Эрдэнэтийн Овоог орд газрын



1-р геологийн экспедиц Булган, Хөвсгөл аймгуудын нутагт геологи хайгуулын ажил явуулах шийдвэр гарчээ.

Энэхүү шийдвэрийг үндэслэн Чехийн баг УБДР-ийн Рурган хүмүүжүүлэх ухааны тэнхимийн профессор Дүгэрсүрэнгийн хамт онгон тахилгат Эрдэнэтийн Овооны орчинд хайгуул, судалгаа хийхээр гарсан байна. Энэ газар хэзээний л оюу чулуу, эрдсийн будаг зэрэг олдогоороо алдартай байсан бөгөөд Чехийн геологичид орон нутгийн хүмүүсээс олж авсан сонирхолтой дээжийн цуглуулгатай

үүднээс ирээдүй багатай гэж үзжээ. Харин тухайн газар нутгаас авсан дээжинд зэсийн агууламж ахиухан байгааг илтгэсэн химийн шинжилгээний үр дүн нь манай геологичидийн сонирхолыг татсан байна.

Геологич Петр Орелын ажлын тэмдэглэлүүдээс харахад Чехийн геологичид Эрдэнэтийн Овоон дээр 1962 оны 9 сарын 30-ны Ням гаригт гарч: "Уулын урд бөгөөд зүүн урд бэлийн дагуу 500м x 500м талбайд жигд бус байдлаар 10-15м өргөнтэй дүгуй хэлбэрийн 15м хүртэл гүн ухмалууд байрласан

